

БАТЛАВ.



МОНГОЛЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ
ДАРГА

Ч.НАРАНТУЯА

МОНГОЛЫН ХУВИЙН
ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН
НЭГДСЭН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨРЧ

Ш.ЗОРИГОО

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2024-2026 ОНЫ ХАМТ /ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР

2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн Нэгдүгээр бүлгийн 5 дугаар зүйл, Хоёрдугаар бүлгийн 13, 14, Гуравдугаар бүлгийн 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30 дугаар зүйл, Дөрөвдүгээр бүлгийн 31, 32, 33, 34, 35, 36 дугаар зүйл, заалтуудыг тус тус үндэслэн энэхүү хамтын хэлэлцээрийг байгуулав.

Хэлэлцээрийн зорилго нь Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэхэд оршино.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн эрүүл мэндийн салбарын хэлэлцээрийг эрүүл мэндийн байгууллагууд хууль тогтоомжийн хүрээнд хамтын хэлэлцээрийг байгуулж болно.

1.2. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, тэдгээрийн харьяа байгууллага, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь хууль, эрх зүйн хүрээнд бодлого шийдвэрээр хэрэгжүүлнэ.

1.3. Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд нь тус хэлэлцээрт заагдсан нөхцөл баталгаанаас дордуулсан тушаал, шийдвэр гаргасан тохиолдолд энэхүү хэлэлцээрийг дагаж мөрдөнө.

1.4. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын ажил олгогч нь хөдөлмөрийн харилцаа, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг байгууллагын нийт ажилтанд жил бүр ил тод мэдээлнэ.

1.5. Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалах, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах талаар талууд нэгдмэл байр суурьтай хамтран ажиллана.

ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР

2.1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлэх тухай Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө талууд хамтран ажиллана.

2.2. Орон нутгийн өмчийн эмнэлгүүдийн байр ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан дагуу санхүүжилтийг хамтран шийдвэрлүүлнэ.

2.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг иргэнд ногдох санхүүжилтийн 20%-ийн олголт болон 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн асуудалд хяналт тавин ажиллана.

2.4. Ажил олгогч нь өндөр насны тэтгэвэр авч байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажиллуулахдаа цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, хөнгөлөлтийг харилцан тохиролцосны дагуу олгоно.

2.5. Ажил олгогч нь хөдөлмөр зохион байгуулалт нь өдрөөр ажиллах горимтой эмч, ажилтнууд илүү цагаар болон дуудагдаж ажилласан, жижүүрт гарч ажилласан тохиолдолд биеэр амруулаагүй бол илүү цагийн хөлсийг ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн зүйл, заалтын дагуу тооцож олгоно.

2.6. Ажил олгогч нь эрүүл мэндийн байгууллагын үйлчлэгч, туслах сувилагчийг богино хугацааны сургалтад үе шаттай хамруулж ажиллана.

2.7. Тодорхой шалтгааны улмаас ажлын байрыг олноор цөөрүүлэх, шилжүүлэх, орон тоо, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ ажил олгогч нь ҮЭ-ийн байгууллагад 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангаж ажиллана.

2.8. Ажлын байрыг олноор цөөрүүлэх, шилжүүлэх, орон тоо бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийх тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 3 жил хүртэл хугацаа дутуу байгаа ажилтан, өрх толгойлсон болон насанд хүрээгүй 2-оос дээш хүүхэдтэй ажилтнуудыг цомхотголд хамруулахгүй байх бөгөөд хэрэв тухайн ажлын байр нь зайлшгүй цомхотголд орсон тохиолдолд өмнө нь авч байсан цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийг бууруулахгүйгээр өөр ажлаар хангана.

2.9. Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй мэргэшсэн эмч, ажилтнуудыг болон үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга болон идэвхтэн, сонгуультнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг баримталж удирдлагын хувийн үзэл бодол, улс төр, намын шугамаар, түүнчлэн үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтай нь

холбогдуулан ажлаас нь чөлөөлөхгүй байх, тэдэнд ажлын байрны дарамт үзүүлэхгүй, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлнэ.

2.10. Эрүүл мэндийн салбарын норм норматив, ажлын цагийн үргэлжлэх хугацаа, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар хамтран ажиллана.

2.11. Ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхэд үйлдвэрчний эвлэлийн хорооны оролцоог хангах үүднээс Удирдлагын багийн бүрэлдэхүүнд үйлдвэрчний эвлэлийн хорооны даргыг оруулна.

2.12. Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарын томилгоонд Төрийн албаны тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг чанд баримтлан тогтвортой ажиллуулна.

2.13. Төрийн үйлчилгээний эрүүл мэндийн байгууллагуудыг хувьчлалаас хамгаалах бодлогыг талууд баримталж ажиллана.

ГУРАВ. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР

3.1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын ажил олгогч нь ажилтнуудын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, бусад нөхөн олговрын хэмжээг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, Засгийн газрын тогтоол болон хамтын гэрээгээр зохицуулж, өмнөх хүрсэн түвшингээс бууруулахгүй ажиллана.

3.2. Эрүүл мэндийн салбарт мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2024 онд 858000 (660000*1.3)төгрөг байна.

3.3. Ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийг байгууллага бүр хамтын гэрээгээр тогтооно.

3.4. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын үндсэн цалинг инфляц, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх, цаашид дундаж цалин хөлсийг 3 сая төгрөгт хүргэхийн төлөө хамтран ажиллана.

3.5. Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл заалтын дагуу шөнийн цаг ажилласны нэмэгдэл хөлсийг тооцон олгоно.

3.6. Эрүүл мэндийн салбарын албан тушаалын ангилал, зэрэглэл шинэчлэгдэхэд хамрагдаагүй ажил мэргэжлүүдийн ангилал зэрэглэлийг шинэчлэх талаар санал боловсруулна.

3.7. ЭМДҮЗ-ийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг шинэчлэн батлахын өмнө цалингийн нэмэгдэл, инфляцын түвшинтэй уялдуулан тарифыг нэмэгдүүлж нэмэлт, өөрчлөлт хийдэг болох асуудлыг холбогдох байгууллагад санал хүргүүлж, түншлэгч талууд хамтран ажиллана.

3.8. Эмч, эмнэлгийн мэргэжилтний үр дүнгийн урамшууллыг улиралд 60 хүртэл хувиар тооцож олгоно.

3.9. Эрсдэлтэй, халдвартай нөхцөлд ажилладаг эмнэл зүйн эмгэг судлал, зоонозын өвчин судлал, халдварт өвчин судлал, цус сэлбэлт судлалын мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажиллах хүчийг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдэл хөлс олгох, төгсөлтийн дараах сургалтын асуудлыг хамтран судална.

3.10. Эрүүл мэндийн салбарын хувийн хэвшлийн байгууллагууд ажилтнуудынхаа үндсэн цалинг төрийн албан хаагчдын цалингийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэхийг төлөө ажиллана.

3.11. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэггүй эрүүл мэндийн байгууллагуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх эх үүсвэрийг улсын төсөвт тусгаж шийдвэрлүүлнэ.

3.12. Ажил олгогч нь ажилтан 1 сар ба түүнээс дээш хугацааны сургалтад хамрагдах үед тухайн ажилтны ажлыг нь хийсэн тохиолдолд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцон олгоно.

3.13. Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооноос зохион байгуулдаг “Алтан чагнуур”, “Эрдэнийн чагнуур” шагналаар шагнагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг ажиллаж буй байгууллагаас нь олгоно.

3.14. Ажил олгогч нь гүйцэтгэлийн үр дүн, бүтээмж, ажлын гүйцэтгэлээр олсон орлого болон үйл ажиллагааны нэмэлт орлогыг ажилтны цалин хөлс, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд 40-өөс доошгүй хувийг зарцуулж гүйцэтгэлийг нийт ажилтанд тайлагнана.

3.15. Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид холбогдох цалингийн нэмэгдлийг олгох нөхцлийг бүрдүүлэхэд хамтарч ажиллана.

3.16. Алсын дуудлага, өвчтөн тээвэрлэж буй нийслэл, орон нутгийн эмч, ажилтанд томилолт болон илүү цагийн хөлсийг холбогдох журмын дагуу олгоно.

3.17. Ажил олгогч нь эрүүл мэндийн салбар хариуцлагатай албан тушаал болох Тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл хөлс олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар хамтран ажиллана.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААР

4.1. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг өмчийн хэлбэр үл харгалзан хөнгөлөлттэй нөхцлөөр болон орон сууцны хөтөлбөрт урьдчилгаагүй хамрагдах, урт хугацааны ипотекийн зээлд хамруулах санхүүгийн эх үүсвэрийг судлан хамтран ажиллана.

4.2. Ажилтнуудад орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломж нөхцөлийг судалж, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр банкуудтай хамтран ажиллана.

4.3. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдээс эмч, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг тэдэнд чиглэсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллана.

4.4. Аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгох асуудлыг хамтран судална.

4.5. Туслах сувилагч, жолооч, ариутгагч, эмнэлгийн тогооч, үйлчлэгч нарыг орон нутгийн нэмэгдэлд хамруулна.

4.6. Эрүүл мэндийн байгууллагад 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан эмч, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах асуудлыг хамтран судална.

4.7. Эрүүл мэндийн салбарын ажлын онцлог байдал, ачааллыг харгалзан 100 хүртэл ажилтантай бол гэрээгээр, 100-аас дээш ажилтантай төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад орон тооны, хувийн хэвшлийн байгууллагад орон тооны эсхүл гэрээт сэтгэл зүйч ажиллуулах асуудлыг цалингийн сандаа багтаан шийдвэрлэнэ.

4.8. Ажил олгогч нь шөнийн ээлжинд ажиллаж буй ажилтнуудыг оройн хоол, өглөөний цайгаар хангахыг хамтын гэрээндээ тусган байгууллагын зардлаар олгоно.

4.9. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн эрүүл мэндийн ажилтанд Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно.

4.10. Салбарын хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүй урлаг, спорт, уулзалт, өдөрлөг, зөвлөгөөн, арга хэмжээг жил бүр бие даан болон талууд хамтран зохион байгуулна.

4.11. Эрүүл мэндийн байгууллагууд дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан ажиллуулах боломжийг судлан шийдвэрлэхийн төлөө ҮЭ-ийн байгууллагатай хамтран, төрөөс хувьсах зардлыг авах замаар ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө зорьж ажиллана.

4.12. Ажилтнуудад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, шагналыг хамтын гэрээгээр зохицуулан олгоно.

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

5.1. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд, ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн гишүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулж, чадавхжуулах ажлыг талууд хамтран зохион байгуулна.

5.2. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулсан амралт, сувилалд хөнгөлөлттэй үйлчлүүлэх асуудлаар талууд санаачилгатай хамтран ажиллана.

5.3. Эрүүл мэндийн салбарын ХАБЭА-н стандартыг боловсруулж, ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн норм стандартын үлгэрчилсэн загварыг баталж, эрүүл, аюулгүй орчин нөхцөлд ажиллах боломжийг хангах үүднээс (өвөл, зуны улиралд) хөдөлмөр хамгааллын иж бүрэн нормын хувцасаар хангах зардлыг байгууллага бүрээр тооцон гаргуулж нэгтгэн холбогдох тооцооллыг хийж улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

5.4. Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангах болон ажлын цагийг богиносгох зохицуулалт хийнэ.

5.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллага бүр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтныг орон тоогоор болон гэрээгээр ажиллуулна.

5.6. Ажлын хэт ачаалал, уртасгасан цагаар ажиллах, ажлаас халшрах хамшинж үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор жижүүрийн хуваарийг эмнэлгүүд дотооддоо өөрсдийн онцлогоо харгалзан хуулийн заалтаас хэтрүүлэхгүй байхаар зохицуулалт хийж мөрдөн ажиллана.

5.7. Эрүүл мэндийн салбарын ажилтнууд өндөр үнэтэй шинжилгээнд хамрагдсан болон хүндээр өвчилсөн тохиолдолд тодорхой нөхцөл байдлыг харгалзан ажиллаж буй байгууллага нь хөнгөлөлт үзүүлнэ.

5.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Төсвийн эрүүл мэндийн байгууллагуудын тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.

5.9. Эрүүл мэндийн байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эсэхэд тухайн байгууллагын Үйлдвэрчний хорооноос хяналт тавьж ажиллана.

5.10. Бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг ажлын байранд тасралтгүй зохион байгуулж, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлж, эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллана.

5.11. Эмч ажилтнуудыг аливаа халдлага, дайралт, гүтгэлэг зэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн орчныг бий болгож, үйлчлүүлэгчдийн хариуцлагын тогтолцоог сайжруулна.

5.12. Үйлдвэрлэлийн осол гаргаагүй болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг үлгэр жишээ зохион байгуулсан, ажилтнуудынхаа хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгааг сайжруулсан, ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилладаг байгууллагын ажил олгогчийг урамшуулна.

5.13. Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагын болон эрүүл мэнд, амь насны даатгал эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сайн дурын даатгал (Эрсдлийн даатгал)-д эрх зүйн орчныг бий болгоход хамтран ажиллана.

5.14. Шөнийн ээлжнээс буусан ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол үргэлжлүүлэн хурал зөвлөгөөн, сургалт зэрэг үйл ажиллагаанд хамрагдахыг шаардахгүй байх талаар байгууллага хамтын гэрээнд тусгана.

5.15. Эмнэлгүүдийн яаралтай тусламж, хүлээн авах тасагт эрсдлийн үнэлгээ хийлгэж, эмзэг бүлгийн иргэд, донтох эмгэгтэй, зан төрхийн өөрчлөлтөд орсон үйлчлүүлэгч эмч ажилтанд аюултай үйлдэл хийх эрсдэлээс сэргийлж тухайн орчныг камержуулах, харуул хамгаалалтын дэмжлэг үзүүлнэ.

5.16. Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн осолд өртөж нас барсан тохиолдолд амь насны даатгалд хамрагдсныг харгалзахгүйгээр ажилтны ар гэрт холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн олговрыг олгоно.

ЗУРГАА. ХАМТЫН АЖИЛЛАГАА, МЭРГЭЖИЛ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

6.1. Хөдөлмөрийн харилцаа, эрүүл мэндийн болон холбогдох хууль, эрх зүйн асуудлаар сургалт, семинар, уулзалт зөвлөгөөнийг хамтран болон дангаар зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтэнд багц цаг олгоно.

6.2. Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцаатай холбогдсон хууль эрх зүйн гарын авлага авлагыг МЭМАҮЭ-ийн холбоо хариуцан хэрэгжүүлэхэд холбогдох мэдээллээр хангаж ажиллана.

6.3. Эрүүл мэндийн салбарын холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны саналыг албан ёсоор бичгээр хүргүүлэн авч, тусгана.

6.4. Эрүүл мэндийн яам нь салбарын байгууллагуудын дэлгэрэнгүй төсөв, гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн ил тод байдлыг ханган хамтран ажиллана.

6.5. Тухайн байгууллага нь төсвийн хуваарилалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах, хяналт тавихад бүх шатны үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангаж, мэдээлэл солилцоно.

6.6. Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулж, үр дүн, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн түншлэлийг хөгжүүлэх тухай Эрүүл мэндийн сайдын албан даалгавар гаргаж эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийн дүн мэдээг албан бичгээр авч байна.

6.7. Хэлэлцээрт оролцогч талууд хөдөлмөр, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар гадаад орны туршлагаас судлах ажлыг хэлэлцээрийн хугацаанд зохион байгуулж, түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлнэ.

6.8. Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, удирдлагуудын ажлыг дүгнэх үзүүлэлтэд хамтын гэрээ байгуулж түүндээ ажилтнуудын цалин хөлс, нийгмийн хамгаалал, ажлын байрны дарамт хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал зэрэг хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлыг тусган ҮЭ-ийн хороотойгоо түншлэлийн зарчмыг баримтлан ажилласан байдлыг оруулж дүгнэнэ.

6.9. Эрүүл мэндийн ажилтны нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өргөх талаар хамтран ажиллаж, эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийн арга хэмжээ, “Алтан чагнуур” болон “Эрдэнийн чагнуур” ёслол хүндэтгэлийн ажиллагааг Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Эрүүл мэндийн яам, Ажил олгогчийн төлөөлөлтэй хамтран зохион байгуулна.

6.10. Эрүүл мэндийн салбарын ололт амжилт, алдаа зөрчлийг нийгэмд зөв замаар хүргэх зорилгоор туршлагатай олон нийттэй харилцах мэргэжилтнийг ажиллуулж, салбарын нэр хүндийг өргөх, хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттай зохион байгуулна.

6.11. Эрүүл мэндийн салбарт тэргүүлэх чиглэлүүдээр анагаах ухааны орчин үеийн өндөр технологи бүхий ололт амжилтыг нутагшуулах, зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэхэд өмчийн хэлбэр харгалзахгүй хамруулж, эмч, мэргэжилтнүүдэд үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлнэ.

6.12. Орчин үеийн анагаах ухааны өндөр технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг жил бүр шалгаруулах үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яам, Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран ажиллаж, шалгарсан байгууллагад төрөөс үзүүлэх дэмжлэг туслалцааг өргөжүүлж, бодит дэмжлэгийг үзүүлнэ.

6.13. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар Аймгийн эрүүл мэндийн газар, тухайн аймгийн ҮЭ-ийн холбоотой, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ МӨРДӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

7.1. Энэхүү хэлэлцээр нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсны дараа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж, бүртгүүлсэн өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Хамтын хэлэлцээрт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг талууд жил бүр хамтран боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.

7.3. Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримтласан журмын дагуу шийдвэрлэнэ.

7.4. Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэнд талууд хамтран хяналт тавьж ажиллана. Хэлэлцээрийн биелэлтийг хамтарсан ажлын хэсэг гарган бүтэн жилээр дүгнэж, нийтэд мэдээлнэ.

7.5. Салбарын хамтын хэлэлцээрийг эрүүл мэндийн удирдах ажилтнуудад танилцуулж, салбарын хэмжээнд хэрэгжүүлнэ.

7.6. Цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбоотой энэхүү хэлэлцээрээр тогтоосон доод хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг тухайн байгууллага хамтын гэрээгээрээ зохицуулна.

7.7. Салбарын хамтын хэлэлцээр хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хамтын ажиллагаа, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх)-ийн биелэлтийг хянах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хамтарсан удирдамжийн хүрээнд зөвлөн туслах үзлэг, хяналт хийнэ.

7.8. Энэхүү хамтын хэлэлцээр нь дараагийн хамтын хэлэлцээр байгуулагдах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

7.9. Эрүүл мэндийн яам, Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, шинэчлэгдэх нь энэхүү хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн залгамжлагчид нь хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ



Д.Очирбат
Төрийн нарийн бичгийн
дарга

МОНГОЛЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООГ
ТӨЛӨӨЛЖ




Л.Энхсайхан
МЭМАҮЭ-ийн холбооны
дэд дарга

АЖИЛ ОЛГОГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:




Ч. Доржгунсмаа
МХХЭМБНХ-ны
гүйцэтгэх захирал


Гишүүд:



С.Эрдэнэтуяа
Төрийн захиргааны
удирдлагын газрын дарга



П.Оюунцэцэг
Бодлого, төлөвлөлтийн
газрын дарга



Л.Лувсан
Санхүү, эдийн засгийн
газрын дарга


А.Өнөржаргал
Эмнэлгийн тусламж,
үйлчилгээний газрын
дарга


Л.Мөнхцэцэг
Санхүү, эдийн засгийн
газрын Санхүү, даатгалын
хэлтсийн дарга



Ш.Мөнгөнцэцэг
ТЗУГ-ын Хуулийн
хэлтсийн шинжээч


Х.Батчимэг
Санхүү, эдийн засгийн
газрын Санхүү, даатгалын
хэлтсийн мэргэжилтэн



А.Энэрэл
Нийтийн эрүүл мэндийн
газрын мэргэжилтэн

Гишүүд:



С.Норжмаа
ГССҮТ-ийн ҮЭ-ийн
хорооны дарга



Б.Нямцэцэг
“Амгалан амаржих газар”
НТТЭ-ийн ҮЭХ-ны дарга


Г.Цэвэлмаа
МЭМАҮЭ-ийн холбооны
тэргүүлэгч


Ч.Оюунбилэг
МЭМАҮЭ-ийн холбооны
тэргүүлэгч



Э.Цогтбаатар
НӨЭМТ-үүдийн
ажилчдийн ҮЭ-ийн
хорооны дарга


Н.Мөнхбат
УАУТХ-ийн ҮЭ-ийн
хорооны дарга



Ё.Улсболд
ЦССҮТ-ийн ҮЭ-ийн
хорооны дарга



Э.Төрмөнх
УГТЭ-ийн ҮЭ-ийн
хорооны дарга

Гишүүд:



М.Цэнгэлсайхан
МХХЭМБНХ-ны менежер



С.Чимэдцэрэн
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн


Д.Бямбасүрэн
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн


Т.Болормаа
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн


Д.Нацагдорж
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн


Н.Гансүх
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн


М.Алтанхуяг
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн


Г.Пүрэвсүрэн
МХХЭМБНХ-ны
Удирдах зөвлөл гишүүн